

БАТЛАВ:  
НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ  
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТУР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ЦОЛМОН

1119282481.ш.5290031


НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ЛАБОРАТОРИД  
MNS ISO/IEC 17025 СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛЭХ, МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН  
БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Тус ажлын даалгавар нь нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын орчны агаарын чанарын хяналт шинжилгээ, сайжруулсан түлш, зуухны хаягдал утааны хийн шинжилгээ, суурин эх үүсвэрийн хяналт шинжилгээний нэгдсэн лабораторид MNS ISO/IEC 17025:2018 стандартын дагуу сорилт, шалгалт тохируулгын лабораторийн чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, стандарт хэмжил зүйн газраас магадлан итгэмжлэгдэх бэлтгэл ажлыг хангахад ашиглагдах болно.

1. Лабораторийн ISO/IEC 17025:2018 стандартын менежментийн тогтолцооны баримт бичгийг боловсруулах..
2. ISO/IEC 17025 менежментийн хүрээг тодорхойлох, удирдлага зохион байгуулалтыг үр нөлөөтэй төлөвлөх зөвлөмж боловсруулах.
3. Чанарын гарын авлага, бодлого, журам, өдөр тутмын бүртгэл, маягтуудыг ISO/IEC 17025 стандартын дагуу боловсруулж, захиалагчид хүлээлгэн өгөх.
4. Хэмжилт, шинжилгээний баталгааг хангах “Чанарын хяналтын хөтөлбөр”-ийг боловсруулах.
5. Хэмжилт шинжилгээ хийх аргын стандарт ажлын зааврууд боловсруулахад нь захиалагч талд арга зүйн дэмжлэг үзүүлэх.
6. ISO/IEC 17025:2018 стандартын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, итгэмжлүүлэх бэлтгэлийг хангах.
7. Лабораторийн удирдлага, удирдах ажилтнуудад зориулсан ISO/IEC 17025:2018 стандартын сургалт хийх.
8. Лабораторийн нийт ажилтнуудад зориулсан ISO/IEC 17025 стандартын танхимын шат дараалсан сургалт болон ижил төстэй дотоодын гадаадын итгэмжлэгдсэн лабораториудтай танилцах сургалт хийх.

9. Лабораторийн менежментийн бодлого, журам, бүртгэл, маягтыг өдөр тутам хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, 6 сарын турш заавар зөвлөгөө өгч ажиллах;
10. MNS ISO/IEC 17025 стандарттаар магадлан итгэмжлэгдэх хүсэлтийг Стандарт хэмжил зүйн төвд гаргах, магадлан итгэмжлэлийн үнэлгээний явцад зөвлөгөө өгч ажиллах.
11. Лабораторийн барилгын зураг төслийг зохиох явцад ISO/IEC 17025 стандартын шаардлагын дагуу лабораторийн өрөөний зохион байгуулалт, тоног төхөөрөмжийн байршил, агааржуулалт, хэмжилт шинжилгээний урсгалын зохистой төлөвлөх зөвлөмж өгөх.

НАБТГ-ЫН Агаарын чанар, хяналт,  
зохион байгуулалтын хэлтсийн дарга



Г.Даваажаргал

НАБТГ-ЫН Орчны хэмжилт  
хариуцсан мэргэжилтэн



M.Отгонбаяр